



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** СЭА-2022/258/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 7036-3040      Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036      Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Т.Болор
	Утас: 7036-2442      Цахим хаяг: <a href="mailto:bolort@audit.gov.com">bolort@audit.gov.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

1. Аудитын санал, дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-14
3. Аудитын тайлан	15
3.1. Ерөнхий зүйл	15
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	21
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	22
3.8. Аудитын гол асуудал	24
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
4. Аудитын илрүүлэлт	26
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	30

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
СДД	Сайн дурын даатгуулагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ЭХМК	Эмнэлэг, хөдөлмөр магадлах комисс



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
С.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

2022.03.25 № СЭА-2022/258-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл


### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,243,997,739.66</b>	<b>33,490,726,679.64</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>7,741,283,332.63</b>	<b>8,606,249,478.71</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>7,741,283,332.63</b>	<b>8,606,249,478.71</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>7,741,283,332.63</b>	<b>8,606,249,478.71</b>
31211	Төрийн сангийн харилцах	13,407,760.51	16,972,077.57
31213	Арилжааны банк дахь харилцах	7,727,875,572.12	8,589,277,401.14
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>20,485,801,174.03</b>	<b>24,876,311,886.43</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	9,418,304,710.20	11,283,597,596.08
33300	Татаас, санхүүжилтийн авлага	10,435,933,195.63	12,859,201,534.70
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>631,563,268.20</b>	<b>733,512,755.65</b>
33510	Байгууллагаас авах авлага	631,461,009.84	732,880,835.29
33520	Хувь хүмүүсээс авах авлага	102,258.36	631,920.36
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>16,913,233.00</b>	<b>8,165,314.50</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>16,913,233.00</b>	<b>8,165,314.50</b>
35410	Бичиг хэргийн материал	2,984,200.00	536,500.00
35420	Аж ахуйн материал	6,190,703.00	4,327,200.00
35430	Сэлбэг хэрэгсэл	859,800.00	859,800.00
35440	Түлш, шатах тослох материал	3,060,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	3,818,530.00	2,441,814.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,396,497,904.88</b>	<b>1,351,045,975.97</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,396,497,904.88</b>	<b>1,351,045,975.97</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,382,060,704.88</b>	<b>1,336,608,775.97</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,387,219,740.11	1,387,219,740.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(101,253,682.31)	(132,572,190.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,800,000.00	12,540,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(41,369,444.45)	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	141,788,653.38	149,647,339.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	(93,164,087.63)	(114,917,326.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	123,807,835.00	123,807,835.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,768,309.22)	(89,116,621.88)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>14,437,200.00</b>	<b>14,437,200.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	14,437,200.00	14,437,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>29,640,495,644.54</b>	<b>34,841,772,655.61</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>397,385,670.83</b>	<b>403,403,261.99</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>397,385,670.83</b>	<b>403,403,261.99</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>144,014,975.34</b>	<b>121,793,564.49</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	143,185,556.94	121,691,546.09
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>829,418.40</b>	<b>102,018.40</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	829,418.40	102,018.40
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>253,370,695.49</b>	<b>281,609,697.50</b>
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	253,370,695.49	281,609,697.50
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>29,243,109,973.71</b>	<b>34,438,369,393.62</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>29,243,109,973.71</b>	<b>34,438,369,393.62</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	349,539,030.02	349,539,030.02

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51200	Хуримтлагдсан үр дүн	28,758,047,189.75	33,953,306,609.66
51210	Өмнөх үеийн үр дүн	16,022,898,200.92	28,842,571,736.20
51220	Тайлант үеийн үр дүн	12,735,148,988.83	5,110,734,873.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	135,523,753.94	135,523,753.94
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>29,640,495,644.54</b>	<b>34,841,772,655.61</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>205,308,169,494.80</b>	<b>118,220,310,262.89</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>51,698,480,865.62</b>	<b>58,797,816,165.21</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>51,698,480,865.62</b>	<b>58,797,816,165.21</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	35,813,391,347.64	41,326,329,481.79
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,669,025,595.00	3,992,174,413.18
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,205,702,040.78	3,607,824,010.57
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	723,207,174.54	788,932,947.03
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,287,154,707.66	9,082,555,312.64
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>155,453,905.44</b>	<b>61,432,384.68</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>155,453,905.44</b>	<b>61,432,384.68</b>
120002	Хүүгийн орлого	143,239,451.11	21,697,249.32
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>11,604,332.33</b>	<b>13,914,635.36</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,992,332.33	13,778,635.36
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	612,000.00	136,000.00
120009	Бусад орлого	610,122.00	10,820,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	12,540,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	2,460,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>153,454,234,723.74</b>	<b>59,361,061,713.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>633,800,000.00</b>	<b>-</b>
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	633,800,000.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>6,209,447.00</b>	<b>285,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,209,447.00	285,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>151,920,117,576.74</b>	<b>58,447,256,713.00</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	151,920,117,576.74	58,447,256,713.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>894,107,700.00</b>	<b>913,520,000.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	894,107,700.00	913,520,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>192,573,020,505.97</b>	<b>113,109,575,389.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>192,573,020,505.97</b>	<b>113,109,575,389.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>934,651,168.99</b>	<b>946,301,062.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>637,532,559.00</b>	<b>653,464,539.88</b>
210101	Үндсэн цалин	520,391,692.00	534,039,274.88
210102	Нэмэгдэл	91,336,867.00	91,509,265.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,804,000.00	18,916,000.00
210104	Урамшуулал	9,000,000.00	9,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>81,852,682.81</b>	<b>87,359,223.34</b>
210201	Тэтгэврийн даатгал	54,792,185.87	60,443,846.62
210202	Тэтгэмжийн даатгал	6,769,216.87	6,726,660.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,410,462.33	5,381,328.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,350,569.27	1,345,332.04

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	13,530,248.47	13,462,056.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,554,877.61</b>	<b>48,281,696.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,546,719.63	5,257,158.07
210302	Түлш, халаалт	34,845,192.70	39,318,737.87
210303	Цэвэр, бохир ус	2,162,965.28	3,705,801.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,569,790.10</b>	<b>30,242,215.28</b>
210401	Бичиг хэрэг	5,790,650.00	11,145,950.00
210402	Тээвэр, шатахуун	11,330,000.00	6,374,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,791,999.10	4,593,132.28
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	410,888.00	308,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,246,253.00	7,820,933.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>710,950.00</b>	<b>2,926,800.00</b>
210604	Урсгал засвар	710,950.00	2,926,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,007,200.00</b>	<b>3,598,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,007,200.00	3,598,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>56,562,480.00</b>	<b>52,090,651.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,138,562.00	35,317,977.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	509,100.00	494,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	197,000.00
210807	Газрын төлбөр	12,744.00	14,368.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,104,050.00	9,748,550.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,366,024.00	6,318,506.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>81,860,629.47</b>	<b>68,337,435.36</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,811,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,860,629.47	66,525,835.36
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>191,638,369,336.98</b>	<b>112,163,274,327.13</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>89,109,733,839.00</b>	<b>92,911,452,924.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	89,077,985,939.00	92,890,629,824.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,867,600.00	7,475,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,880,300.00	13,348,100.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>102,528,635,497.98</b>	<b>19,251,821,403.13</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	102,528,635,497.98	19,251,821,403.13
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>12,735,148,988.83</b>	<b>5,110,734,873.46</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>12,735,148,988.83</b>	<b>5,110,734,873.46</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,539,030.02	135,523,753.94	15,981,025,491.91	16,466,088,275.87
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	41,872,709.01	41,872,709.01
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	349,539,030.02	135,523,753.94	16,022,898,200.92	16,507,960,984.88
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	12,735,148,988.83	12,735,148,988.83
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,539,030.02	135,523,753.94	28,758,047,189.75	29,243,109,973.71
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	349,539,030.02	135,523,753.94	28,758,047,189.75	29,243,109,973.71
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	84,524,546.45	84,524,546.45
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	349,539,030.02	135,523,753.94	28,842,571,736.20	29,327,634,520.16
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	5,110,734,873.46	5,110,734,873.46
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,539,030.02	135,523,753.94	33,953,306,609.66	34,438,369,393.62

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>196,764,443,620.81</b>	<b>114,212,154,464.48</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>42,274,259,922.05</b>	<b>54,436,497,583.82</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>42,274,259,922.05</b>	<b>54,436,497,583.82</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	28,612,814,473.40	39,209,441,856.89
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,726,895,539.07	3,154,546,248.32
112003	ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл	2,062,531,628.18	2,684,902,944.87
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	538,880,834.44	619,091,948.72
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,333,137,446.96	8,768,514,585.02
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,717,146,116.40</b>	<b>227,640,080.66</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,717,146,116.40</b>	<b>227,640,080.66</b>
120002	Хүүгийн орлого	143,239,451.11	21,697,249.32
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,573,906,665.29</b>	<b>205,942,831.34</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,573,294,665.29	205,806,831.34
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	612,000.00	136,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>152,773,037,582.36</b>	<b>59,548,016,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>-</b>	<b>197,437,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	197,437,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>6,209,447.00</b>	<b>285,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,209,447.00	285,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>151,872,720,435.36</b>	<b>58,436,774,000.00</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	151,872,720,435.36	58,436,774,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>894,107,700.00</b>	<b>913,520,000.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	894,107,700.00	913,520,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>193,996,322,901.28</b>	<b>113,347,188,318.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>193,996,322,901.28</b>	<b>113,347,188,318.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>856,948,780.92</b>	<b>871,296,136.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>638,151,257.00</b>	<b>653,994,201.88</b>
210101	Үндсэн цалин	508,016,140.00	518,157,638.88
210102	Нэмэгдэл	94,420,622.00	110,685,363.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,076,000.00	16,151,200.00
210104	Урамшуулал	22,638,495.00	9,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>81,852,682.81</b>	<b>87,359,223.34</b>
210201	Тэтгэврийн даатгал	54,792,185.87	60,443,846.62
210202	Тэтгэмжийн даатгал	6,769,216.87	6,726,660.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,410,462.33	5,381,328.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,350,569.27	1,345,332.04
210205	Эрүүл мэндийн даатгал	13,530,248.47	13,462,056.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,905,924.01</b>	<b>48,281,696.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,546,719.63	5,257,158.07
210302	Түлш, халаалт	38,196,239.10	39,318,737.87

**Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210303	Цэвэр, бохир ус	2,162,965.28	3,705,801.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,916,777.10</b>	<b>20,361,012.28</b>
210401	Бичиг хэрэг	8,774,850.00	8,698,250.00
210402	Тээвэр, шатахуун	14,390,000.00	3,314,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,791,999.10	4,593,132.28
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	410,888.00	308,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,549,040.00	3,447,430.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>710,950.00</b>	<b>6,706,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,779,400.00
210604	Урсгал засвар	710,950.00	2,926,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,007,200.00</b>	<b>3,598,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,007,200.00	3,598,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>49,403,990.00</b>	<b>49,183,702.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,138,562.00	35,317,977.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	509,100.00	494,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	197,000.00
210807	Газрын төлбөр	12,744.00	14,368.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,104,050.00	9,748,550.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,207,534.00	3,411,557.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>-</b>	<b>1,811,600.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,811,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>193,139,374,120.36</b>	<b>112,475,892,181.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>90,610,738,622.38</b>	<b>93,224,376,638.83</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	89,107,099,571.84	93,006,680,341.48
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,867,600.00	7,475,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,471,891,150.54	196,873,197.35
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,880,300.00	13,348,100.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>102,528,635,497.98</b>	<b>19,251,515,543.13</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	102,528,635,497.98	19,251,515,543.13
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,768,120,719.53</b>	<b>864,966,146.08</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>2,768,120,719.53</b>	<b>864,966,146.08</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,973,162,613.10	7,741,283,332.63
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,741,283,332.63	8,606,249,478.71

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>94,729,347,000.00</b>	<b>93,895,102,720.92</b>	<b>834,244,279.08</b>	<b>99.12</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>94,729,347,000.00</b>	<b>93,895,102,720.92</b>	<b>834,244,279.08</b>	<b>99.12</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>896,976,900.00</b>	<b>867,599,279.44</b>	<b>29,377,620.56</b>	<b>96.72</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>664,666,700.00</b>	<b>653,994,201.88</b>	<b>10,672,498.12</b>	<b>98.39</b>
210101	Үндсэн цалин	530,315,700.00	518,157,638.88	12,158,061.12	97.71
210102	Нэмэгдэл	107,299,800.00	110,685,363.00	(3,385,563.00)	103.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,051,200.00	16,151,200.00	1,900,000.00	89.47
210104	Урамшуулал	9,000,000.00	9,000,000.00	-	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>88,712,800.00</b>	<b>87,359,223.34</b>	<b>1,353,576.66</b>	<b>98.47</b>
210201	Тэтгэврийн даатгал	62,124,100.00	60,443,846.62	1,680,253.38	97.30
210202	Тэтгэмжийн даатгал	6,647,200.00	6,726,660.20	(79,460.20)	101.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,317,700.00	5,381,328.16	(63,628.16)	101.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,329,400.00	1,345,332.04	(15,932.04)	101.20
210205	Эрүүл мэндийн даатгал	13,294,400.00	13,462,056.32	(167,656.32)	101.26
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>48,392,800.00</b>	<b>48,281,696.94</b>	<b>111,103.06</b>	<b>99.77</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,286,400.00	5,257,158.07	29,241.93	99.45
210302	Түлш, халаалт	39,390,700.00	39,318,737.87	71,962.13	99.82
210303	Цэвэр, бохир ус	3,715,700.00	3,705,801.00	9,899.00	99.73
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,936,600.00</b>	<b>20,361,012.28</b>	<b>10,575,587.72</b>	<b>65.82</b>
210401	Бичиг хэрэг	8,782,100.00	8,698,250.00	83,850.00	99.05
210402	Тээвэр, шатахуун	13,291,100.00	3,314,000.00	9,977,100.00	24.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,863,400.00	4,593,132.28	270,267.72	94.44
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	308,200.00	191,800.00	61.64
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	3,447,430.00	52,570.00	98.50
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,000,000.00</b>	<b>6,706,200.00</b>	<b>293,800.00</b>	<b>95.80</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	3,779,400.00	220,600.00	94.49

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	3,000,000.00	2,926,800.00	73,200.00	97.56
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,310,300.00</b>	<b>3,598,500.00</b>	<b>711,800.00</b>	<b>83.49</b>
210702	Дотоод албан томилолт	4,310,300.00	3,598,500.00	711,800.00	83.49
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>50,957,700.00</b>	<b>45,486,845.00</b>	<b>5,470,855.00</b>	<b>89.26</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,750,700.00	35,032,977.00	2,717,723.00	92.80
210803	Даатгалын үйлчилгээ	494,300.00	494,250.00	50.00	99.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,500.00	197,000.00	1,500.00	99.24
210807	Газрын төлбөр	15,000.00	14,368.00	632.00	95.79
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12,499,200.00	9,748,250.00	2,750,950.00	77.99
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>1,811,600.00</b>	<b>188,400.00</b>	<b>90.58</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,811,600.00	188,400.00	90.58
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>93,832,370,100.00</b>	<b>93,027,503,441.48</b>	<b>804,866,658.52</b>	<b>99.14</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>93,832,370,100.00</b>	<b>93,027,503,441.48</b>	<b>804,866,658.52</b>	<b>99.14</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	93,804,115,300.00	93,006,680,341.48	797,434,958.52	99.15
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,500,000.00	7,475,000.00	25,000.00	99.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,754,800.00	13,348,100.00	7,406,700.00	64.31
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>94,729,347,000.00</b>	<b>45,909,041,928.27</b>	<b>48,820,305,071.73</b>	<b>48.46</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>17,899,631,800.00</b>	<b>197,437,800.00</b>	<b>17,702,194,000.00</b>	<b>1.10</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	17,899,631,800.00	197,437,800.00	17,702,194,000.00	1.10
33	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>76,829,715,200.00</b>	<b>45,687,141,644.19</b>	<b>31,142,573,555.81</b>	<b>59.47</b>
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	76,829,715,200.00	45,687,141,644.19	31,142,573,555.81	59.47

**Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	<b>24,462,484.08</b>	<b>(24,462,484.08)</b>	-
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	24,326,408.96	<b>(24,326,408.96)</b>	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	136,075.12	<b>(136,075.12)</b>	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,741,283,332.63	<b>(7,741,283,332.63)</b>	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8,606,249,478.71	<b>(8,606,249,478.71)</b>	-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>119.00</b>	<b>119.00</b>	-	<b>100.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	-	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>59.00</b>	<b>59.00</b>	-	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	49.00	49.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00	-	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>59.00</b>	<b>59.00</b>	-	<b>100.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	50.00	50.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00	-	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>285,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>285,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>285,000.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>285,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	285,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>285,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>285,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	285,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс /цаашид Нийгмийн даатгалын хэлтэс гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдүүлэлт, авлага барагдуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийгмийн даатгалын хэлтэс нь тайлант онд “Нэг бүртгэл, нэг хяналт” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа хэрэгжүүлсэн бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах,
- Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх,
- Нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлтийг хангах, уг сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт үйлчилгээний зардлыг цаг тухайд нь олгох,
- Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагч иргэдэд шуурхай чирэгдэлгүй хүргэх,
- Үйлчилгээний чанар, хүртээмж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах,
- Даатгалын үйлчилгээнд дэвшилтэд хэлбэр, маркетингийг нэвтрүүлэх,
- Менежментийн чадавхыг бэхжүүлэх, ажилтнуудыг чадваржуулах,
- Хууль тогтоомжийг сурталчлах ажлыг шинэ шатанд гаргах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Нийгмийн даатгалын тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр даатгуулагч болон ажил олгогчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2021 оны 07 сарын 01-ний өдрөөс тус бүр 1 хувиар бууруулсан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах **босго үнэ** шинэчлэгдсэн,
- Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахтай холбоотой,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.


Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд НДЕГ-ын Дотоод аудит, мониторингийн газраас тус хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй, харин тус хэлтсийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгаас хийсэн хяналт шалгалтаар 130,093.7 мянган төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж, 50.7 хувийг барагдуулсан нь тайлант хугацааны эцэст хяналт шалгалт хийсэнтэй холбоотой байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл



баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны зардлыг бодитоор харуулдаг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 101,847,700.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,018,477.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 763,857.7 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 7,741,283.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 8,606,249.5 мянган төгрөг болж, 864,966.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банкинд байгаа бэлэн мөнгө	7,741,283.30	8,606,249.50	864,966.20	10.05
<b>Дүн</b>	<b>7,741,283.30</b>	<b>8,606,249.50</b>	<b>864,966.20</b>	<b>10.05</b>

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд төрийн сангийн 7 харилцах дансанд байршиж буй 16,972.1 мянган төгрөг, арилжааны 4 банкин дахь 95 харилцах дансанд байршиж буй 8,589,277.4 мянган төгрөг зэрэг нийт 8,606,249.5 мянган төгрөг тайлагнагдсан байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 20,485,801.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 24,876,311.8 мянган төгрөг болж, 4,390,510.6 мянган төгрөгөөр буюу 21.4 хувиар өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
НДШ-ийн авлага.	9,418,304.70	11,283,597.60	1,865,292.90

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Татаас, санхүүжилтийн авлага	10,435,933.20	12,859,201.50	2,423,268.30
Байгууллагаас авах авлага	631,461.00	732,880.80	101,419.80
Хувь хүмүүсээс авах авлага	102.30	631.90	529.60
<b>Дүн</b>	<b>20,485,801.20</b>	<b>24,876,311.80</b>	<b>4,390,510.60</b>

Авлагын дансны үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- 456 байгууллагын 11,283,009.0 мянган төгрөгийн /1 жил хүртэл хугацаагаар төлөөгүй 5,680,703.8 мянган төгрөг, 1-2 жил 3,839,637.4 мянган төгрөг, 2-3 жил 854,588.0 мянган төгрөг, 3-4 жил 358,786.5 мянган төгрөг, 4-өөс дээш жил төлөөгүй 549,293.3 мянган төгрөгийн авлагууд байна./, өмнөх оны хяналт шалгалтын акт, алдангийн 588.6 мянган төгрөгийн зэрэг нийт 11,283,597.6 мянган төгрөгийн НДШ-ийн авлага,

- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн дагуу 2020 онд 4370, 2021 онд 4200 аж ахуйн нэгж, СДД-ийн шимтгэл чөлөөлөлтөд хамрагдсаны 12,225,401.5 мянган төгрөгийн шимтгэлээс чөлөөлөх авлага, 88 байгууллагын 633,800.0 мянган төгрөгийн ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон дэмжлэгийн авлага зэрэг нийт 12,859,201.5 мянган төгрөгийн улсын төсвөөс авах татаас, санхүүжилтийн авлага,

- 17 сум, 5 тосгонд байрлах нэгж хоорондын 499,065.7 мянган төгрөгийн, 98 байгууллага, аж ахуйн нэгжтэй холбоотой 62,034.7 мянган төгрөгийн, 435 иргэнтэй холбоотой 171,780.4 мянган төгрөгийн зэрэг нийт 732,880.8 мянган төгрөгийн бусад авлага,

- 1 албан хаагчид илүү тооцож, олгосон 529.7 мянган төгрөгийн цалингийн авлага тайлант онд үүссэн байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 16,913.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 8,165.3 мянган төгрөг болж, 8,747.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	2,984.20	536.50	(2,447.70)
Аж ахуйн материал	6,190.70	4,327.20	(1,863.50)
Сэлбэг хэрэгсэл	859.80	859.80	-
Түлш, шатах тослох материал	3,060.00	-	(3,060.00)
Бусад хангамжийн материал	3,818.50	2,441.80	(1,376.70)
<b>Дүн</b>	<b>16,913.20</b>	<b>8,165.30</b>	<b>(8,747.90)</b>

Энэ нь тайлант онд 26,996.7 мянган төгрөгийн материал худалдан авсан, 35,744.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан буюу өмнөх оны бараа материалын үлдэгдлээс голлон зарцуулснаас шалтгаалжээ.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,709,053.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,687,652.0 мянган төгрөг болж, 21,401.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	1,387,219.70	1,387,219.70	-
Авто-тээврийн хэрэгсэл	41,800.00	12,540.00	(29,260.00)
Машин тоног төхөөрөмж	141,788.70	149,647.30	7,858.60
Тавилга, аж ахуйн эд хогшил	123,807.80	123,807.80	-
Бусад биет бус хөрөнгө	14,437.20	14,437.20	-
<b>Дүн</b>	<b>1,709,053.40</b>	<b>1,687,652.00</b>	<b>(21,401.40)</b>

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 21,401.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 3,779.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, НДЕГ-аас 5,185.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан болон 1,105.7 мянган төгрөгийн тог баригчийг ТӨБЗГ-ын даргын 2021 оны 413 дугаар тогтоолын дагуу акталж, данс бүртгэлээс хассан, 2021 оны 704 дүгээр тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дууссан 41,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг данснаас хасаж, ашиглах хугацаа сунгагдсан хөрөнгийг 12,540.0 мянган төгрөгөөр үнэлж орлого авснаас шалтгаалсан байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 397,385.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 403,403.2 мянган төгрөг болж, 6,017.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Бараа үйлчилгээний зардлын өглөг	143,185.60	121,691.50	(21,494.10)	(17.66)
Байгууллагад төлөх өглөг	829.40	102.00	(727.40)	7 дахин
Урьдчилж орсон орлого	253,370.70	281,609.70	28,239.00	10.03
<b>Дүн</b>	<b>397,385.70</b>	<b>403,403.20</b>	<b>6,017.50</b>	<b>1.49</b>

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд дараах өглөгүүд тайлагнагдсан байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын сангаас иргэдэд олгох 7,313.2 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас иргэдэд олгох 17,969.2 мянган төгрөг, 17 сум, 5 тосгонд байрлах нэгж хоорондын 30,135.3 мянган төгрөг, 52 байгууллага, аж ахуйн нэгжтэй холбоотой 29,647.9 мянган төгрөг, 967 иргэнтэй холбоотой 36,625.9 мянган төгрөг зэрэг нийт 121,691.5 мянган төгрөгийн өглөг,

- Тэтгэмж болон ажилгүйдлийн даатгалын сангийн банкны үйлчилгээний хураамж 727.4 мянган төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлж, 102.0 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй,

- НДШ урьдчилж төлсөн 364 байгууллагын 37,392.8 мянган төгрөгийн, СДД-аас НДШ урьдчилж төлсөн 2339 иргэний 77,745.3 мянган төгрөгийн, Ажилласан жил нөхөн тооцох тухай хуулиар нөхөн даатгалын шимтгэлийг дутуу төлснөөс шалтгаалан ажилласан жилээ тооцуулж чадаагүй 307 иргэнтэй холбоотой 6,230.6 мянган төгрөгийн, 0-3 насны

хүүхдээ асарч буй 544 эхийн сайн дурын даатгалын шимтгэлд урьдчилан төлсөн 160,241.0 мянган төгрөгийн зэрэг нийт 281,609.7 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 29,243,110.0 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 34,438,800.0 мянган төгрөг болж, 5,195,690.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	349,539.00	349,539.00	-	-
Өмнөх үеийн үр дүн	16,022,898.20	28,842,571.70	12,819,673.50	44.45
Тайлант үеийн үр дүн	12,735,149.00	5,110,734.90	(7,624,414.10)	(149.18)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	135,523.80	135,523.80	-	-
<b>Дүн</b>	<b>29,243,110.00</b>	<b>34,438,369.40</b>	<b>5,195,259.40</b>	<b>15.09</b>

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5.7 Орлогын данс

**НДШ-ийн орлого:** Тус хэлтэс нь 2021 онд 39,005,149.6 мянган төгрөгийн НДШ-ийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 46,281,352.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 38,306,137.4 мянган төгрөг,
- Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого 3,714,514.8 мянган төгрөг,
- ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн орлого 3,337,955.3 мянган төгрөг,
- Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого 922,744.8 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

**Хүүгийн орлого:** Арилжааны 4 банктай хамтран ажиллах гэрээний дагуу нийгмийн даатгалын сангийн харилцах дансны үлдэгдэлд бодож, олгосон хүүгийн орлого **21,697.2** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

**Төсөвт байгууллагын өөрийн орлого:** Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хугацаандаа шимтгэлээ төлөөгүй 22 аж ахуйн нэгж, байгууллагад 2,649.5 мянган төгрөгийн, 510 сайн дурын нийгмийн даатгалын даатгуулагчдад 11,265.1 мянган төгрөгийн алдангийг ногдуулж, **13,914.6** мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын шимтгэл	33,715,182.90	38,306,137.40	4,590,954.50	113.60
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,709,945.30	3,714,514.80	1,004,569.50	137.10
ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл	2,027,748.80	3,337,955.30	1,310,206.50	164.60
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	552,272.60	922,744.80	370,472.20	167.10
Банкны хүүгийн орлого	-	21,697.20	21,697.20	-
Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	13,914.60	13,914.60	-
<b>Нийт дүн</b>	<b>39,005,149.60</b>	<b>46,316,964.10</b>	<b>7,311,814.50</b>	<b>118.80</b>

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 13.6 хувь, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого 20.5 хувь, ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн орлого 64.6 хувь ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого 67.1 хувиар тус тус давж биелсэн нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор НДШ-ийн орлогын төлөвлөгөөг багаар тооцож, баталснаас шалтгаалсан байна. Үүнд:

- НДЕГ-аас улсын хэмжээнд “Ковид-19” цар тахалтай холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагууд хэвийн горимд ажиллахгүй байх,
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2021 оноос 2 хувиар нэмэгдүүлэхээр заасан ч хэрэгжих магадлал бага байсан,
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг тайлант оны 1-6 сард ажил олгогч 1%, даатгуулагч 1 хувь, нийт 2 хувиар нэмэгдүүлэн тооцож, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчингүй болсноос голлон нөлөөлсөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн / үйл ажиллагаа болон сангийн / 2021 оны төсвийн төсөлд үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 91,622,964.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 3,106,382.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, **94,729,347.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Энэ нь цалин, хөлс болон НДШ-ийн зардлыг 264,866.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 30,509.5 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 27,772.6 мянган төгрөгөөр бууруулж, урсгал шилжүүлгийг 3,458,669.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр **94,729,347.0** мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс

17,899,631.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 76,829,715.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 197,437.8 мянган төгрөг, аймгийн нийгмийн даатгалын сангаас 45,687,141.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 24,462.5 мянган төгрөг, НДЕГ-аас *Уулсын НДС-аас* 47,986,060.8 мянган төгрөг зэрэг нийт 93,895,102.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **93,895,102.7** мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 12,026.1 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 10,575.6 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж 797,435.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансаар НДЕГ-аас сургалтын дэмжлэгт зориулан хуваарилсан 285.0 мянган төгрөгийг хүлээн авч, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хамралтыг нэмэгдүүлэх аяны зардалд 285.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. НДЕГ-ын даргын 2021 оны Б/74 дүгээр тушаалаар Санхүү бүртгэлийн тасгийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Б.Бат-Оршихт 739.6 мянган төгрөг, тус хэлтсийн даргын 2021 оны Б/39 дүгээр тушаалаар үйл ажиллагааны нягтлан бодогч А.Баасансүрэнд 337.2 мянган төгрөг, сангийн нягтлан бодогч Н.Уранчимэгт 359.1 мянган төгрөг, М.Баярчимэгт 337.2 мянган төгрөг зэрэг нийт **1,773.1** мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгох шийдвэр гаргасан байна.

Иймд тухайн албан тушаалтнууд холбогдох хууль эрхийн актын дагуу улирал бүр ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал авч байхад санхүүгийн тайлангаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан, санхүүгийн үйл ажиллагаа сайн гэх үндэслэлээр буюу улирлын ажлын үр дүнгийн зөвхөн 1 үзүүлэлтийг үндэслэн урамшууллыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн, давхардуулан олгох шийдвэрийг төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс гаргахгүй байх нь зүйтэй юм.

2. Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг **улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ**”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 3.1-д “Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно” 3.1.4: “Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтнаар 1996 оны 8 дугаар сарын 1-нээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа” гэж зохицуулсан байдаг.

Гэтэл өндөр насны тэтгэвэр тогтоолгосон жижүүр А.Сарантуяагийн Мод боловсруулах комбинат, Туг сонин, Алтанбулаг кино театр /тухайн үеийн нэрээр/ зэрэг үйлдвэр, үйлчилгээний газруудад ажиллаж байсан 8 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, буцалтгүй тусламж олгохоор НДЕГ-аас хянаж, ирүүлсний дагуу нийт 13,348.1 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь дээрх үйлдвэр, үйлчилгээний газрууд нь улсын төсөвт үйлдвэрийн газар мөн эсэх талаарх эрсдэл үүсгэж байгаа учир төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж, тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

3. Төсвийн төлөвлөлтийг зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс 213209-Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал дээр батлах байгууллагын дотоод журмын дагуу олгох 7,475.0 мянган төгрөгийн тэтгэмжийг 213204-Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардалд, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал дээр батлах ёстой 33,028.8 мянган төгрөгийн ЭХМК-ийн урамшуулал, гэрээтийн цалинг 210801-Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тус тус баталж, санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалттай нийцэхгүй тул цаашид зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

4. Тус хэлтсийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлд ашиглагдаж байгаа санхүүгийн программ нь санхүүгийн тайлан мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийг боловсруулахад хүндрэлтэй, санхүүгийн тайлан тодруулга нь стандартын дагуу дансны төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээний ангиллаар илэрхийлэгдээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ыг хангахгүй байна. Өмнөх онуудад хийгдсэн аудитаар уг асуудлыг удирдлагын анхааралд хандуулж байсан боловч өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй байгаа тул санхүүгийн программ хангамжид

тавигдах стандарт шаардлагыг хангасан санхүүгийн программ ашиглах шаардлагатай юм.

5. Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг "0" болсон 89,421.3 мянган төгрөгийн 19 нэр төрлийн хөрөнгийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн 49 дэх "... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" гэсэн заалтын дагуу "0" үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

6. 17 сум, 5 тосгонд байрлах нэгж хоорондын 499,065.7 мянган төгрөгийн, 98 байгууллага, аж ахуйн нэгжтэй холбоотой 62,034.7 мянган төгрөгийн, 435 иргэнтэй холбоотой 171,780.4 мянган төгрөгийн зэрэг нийт 732,880.8 мянган төгрөгийн бусад авлага тайлагнагдсан байна. Эдгээр авлагын эзэн холбогдогчийг тодорхой болгож, барагдуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

### 3.8 Аудитын гол асуудал

2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд **Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны төсвийн** мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроож, 134 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Дараах мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

1. Байгууллагын батлагдсан төсөв, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн мэдээллийг тус бүр 1 удаа,
2. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн мэдээллийг 2 удаа,
3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий

худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг тус бүр 3 удаа,

4. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг 5 удаа.

**Нийгмийн даатгалын сангийн** мэдээлбэл зохих 23 төрлийн 161 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, 159 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

**Нийгмийн даатгалын хэлтсийн** тайлант оны үйл ажиллагаанд 913,520.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 879,461.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.7 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: "... батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 17,874.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 7,857.9 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт № 8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	17,874.2	1	17,874.2	100.0
Зөвлөмж	3	7,857.9	2	7,857.9	66.7
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>25,732.1</b>	<b>3</b>	<b>25,732.1</b>	<b>75.0</b>

Шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд

нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан сумдад хуваарилж буй санхүүжилт, орлого төвлөрүүлэлт, тэтгэвэр, тэтгэмжийн тооцоолол, баримтын бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгах боломжгүй байлаа.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 210,990.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3,779.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,887.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 127,850.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 77,472.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

##### 4.1 Залруулга

1. Бараа материалын дансанд тайлант онд худалдан авсан 3,779.4 мянган төгрөгийн 6 ширхэг принтер бүртгэсэн байсныг санхүүгийн тайланд залрууллаа.

##### 4.2 Төлбөрийн акт

1. Аудитын явцад Мандал, Сүхбаатар сумын ажилгүйдлийн тэтгэмж олголтыг түүвэрлэн шалгахад ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаанд ажил эрхэлснээс шалтгаалан Мандал сумын иргэн У.Түмэнжаргал, Г.Уугансүвд нарт нийт 1,887.7 мянган төгрөгийн /У.Түмэнжаргалд 1,412.4 мянган төгрөг, Г.Уугансүвдэд 475.3 мянган төгрөг/ тэтгэмжийг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ..", Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам"-ын 5.6 дахь "Тэтгэмж авагч нь ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон, ... бол ... мэдэгдэн, тэтгэмж олголтыг зогсоож, тооцоо хийж, ..." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

##### 4.3 Албан шаардлага

1. Мандал сумын Нийгмийн даатгалын тасагтай холбоотой үүссэн 103,743.1 мянган төгрөгийн авлага, 12,501.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж, баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд нэгтгэгдсэн өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Аудитын явцад Мандал, Сүхбаатар сумын ажилгүйдлийн тэтгэмж олголтыг түүвэрлэн шалгахад Мандал сумын Нийгмийн даатгалын тасаг нь 5 хүний 11,076.1

мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг бөөн дүнгээр олгосон байгаа нь Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлд "Ажилгүйдлийн тэтгэмжийг хөдөлмөр эрхлэлтийн алба уг алба байхгүй бол нийгмийн даатгалын байгууллага сард 2 хүртэл удаа тооцож олгоно" гэж заасныг зөрчсөн бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3. Цалингийн тооцооллыг зөрүүтэй хийсний улмаас ажиллагсадтай холбогдсон 529.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4. Өмнөх оны аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргаж, "Шилэн дансны цахим хуудас"-т мэдээлбэл зохих 149 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 дахь "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх", 6 дугаар зүйлийн 6.1-6.4, 6.10 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, тогтоосон хугацаанд мэдээллийг байршуулж байх албан шаардлага хүргүүлэх.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 17,375.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ зөрчил нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн

баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх

**1.1.2 Өгсөн зөвлөмж:** Төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

**1.2.1 Илрүүлэлт:** Тайлант онд 2,362.5 мянган төгрөгийн албан томилолтын гүйлгээг бүрдэл дутуу, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй томилолтын хуудсыг үндэслэн гүйцэтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ... хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2.2 Өгсөн зөвлөмж:** Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр бараа материалын зарцуулалтын ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

## **2. Авлагатай холбоотой асуудал**

**2.1 Илрүүлэлт:** Тайлант онд тус хэлтсийн дотоод хяналт шалгалтаар тогтоогдсон зөрчлийн зөрүү 57,734.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Энэ зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн зөрүү болох дээрх авлагыг барагдуулах арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	6	210,990.2	1	3,779.4	1	1,887.7	1	127,850.5	3	77,472.6
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>210,990.2</b>	<b>1</b>	<b>3,779.4</b>	<b>1</b>	<b>1,887.7</b>	<b>1</b>	<b>127,850.5</b>	<b>3</b>	<b>77,472.6</b>
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	-	-	-	-	-	-	1	-	-	-
<b>Дүн</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>		<b>7</b>	<b>210,990.2</b>	<b>1</b>	<b>3,779.4</b>	<b>1</b>	<b>1,887.7</b>	<b>2</b>	<b>127,850.5</b>	<b>3</b>	<b>77,472.6</b>